

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан.....	4
2.1	Оршил .....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.11	Шилэн дансны мэдээлэл.....	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал.....	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	15
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	17
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	19
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	20
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	22

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

ӨНӨР БҮЛ ХҮҮХДИЙН ТӨВИЙН  
ЗАХИРАЛ М.ӨЛЗИЙЧИМЭГ  
ТАНАА

2019.02.25 № 06/314  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өнөр бүл хүүхдийн төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Өнөр бүл хүүхдийн төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Өнөр бүл хүүхдийн төвийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2 АУДИТЫН ТАЙЛАН**

### **2.1 Оршил**

Өнөр бүл хүүхдийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус төвийн захирал М.Өлзийчимэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1,18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өнөр бүл хүүхдийн төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өнөр бүл хүүхдийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 1 дүгээр сарын 18-наас 2019 оны 2 дугаар сарын 21-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Санхүүч-аудит” ХХК-ийн аудитор Б.Энхсүрэн, аудиторын туслах Ж.Ганзориг нар хариуцаж хэрэгжүүлэв.

Өнөр бүл хүүхдийн төв 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Санхүүч-аудит” ХХК-нд 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 19 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрхзүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Өнөр бүл хүүхдийн төвийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго: Өнөр бүл хүүхдийн төв нь 2-18 насны 310 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай. Хүүхдийн эрхийг хүндлэн дээдэлж, оролцоонд тулгуурлан бүтээлч сэтгэхүйг хөгжүүлж амьдрах ухааны дадал чадвар эзэмшүүлэх, хүүхэд бүрийн амь нас, эрүүл мэнд аюулгүй байдлыг хангах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл: Өнөр бүл хүүхдийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Бүтэн өнчин,
- Эцэг эх байх эрх нь хязгаарлагдсан
- Эцэг эх нь хориход байгаа
- Эцэг эх нь сэтгэцийн өвчтэй
- Эцэг эх нь хөдөлмөрийн чадвараа 70 хувиас дээш алдсан иргэдийн зорилтот бүлгийн хүүхдүүдийг хүлээн авч үйлчилгээнд хамруулах.

Өнөр бүл хүүхдийн төвийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Өнөр бүл хүүхдийн төвийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн

бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчны томоохон шинэчлэл, өөрчлөлт гараагүй байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Өнөр бүл хүүхдийн төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Өнөр бүл хүүхдийн төв санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Acolous" санхүүгийн програм хангамж ашигладаг байна.

Өнөр бүл хүүхдийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

## **2.6 Төлөвлөлтийн шатанл тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Өнөр бүл хүүхдийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 14 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 14 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## 2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 1.0 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь тус төв нь төсвөөс санхүүждэг төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлдэг байгууллага учир нийт зардлыг суурь болгох нь зүйтэй гэж үзэв.

Өнөр бүл хүүхдийн төвийн 2018 оны нийт зардал 1,901,715.1 мянган төгрөг бөгөөд түүний 1.0 хувь болох 19,017.15 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1.0 хувиар тооцсон нь нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөсөнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим, сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 14 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 6 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 7 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал:

				/мянган төгрөгөөр/
№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	4	29,693.6	
2	Төлбөрийн акт тогтоосон	2	7,073.8	
	<b>Дүн</b>	<b>6</b>	<b>36,767.4</b>	

### 2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Санхүүгийн үр дүнгийн тайлан мөнгөн гүйлгээний тайлангийн уялдааг тулган нягтлахад 4,869.1 мянган төгрөг зөрүүтэй тайлагнасан байна.

*Шийдвэрлэсэн нь:* Аудитын хугацаанд санхүүгийн тайланд залруулав.

2. Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайланд нэмэлт санхүүжилтийн дансны төвлөрүүлсэн үлдэгдлийг оруулж тайлагнаагүй байсан нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйл, Сангийн сайдын 2013 оны 76 дугаар тушаалыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Аудитын хугацаанд санхүүгийн тайланд залруулав.

3. Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төлөвлөгөө зөрүүтэй тусгасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйл, Сангийн сайдын 2013 оны 76 дугаар тушаалыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Аудитын хугацаанд санхүүгийн тайланд залруулав

4. Мөнгөн гүйлгээний тайланд өмнөх оны гүйцэтгэл хагас жилийн дүнгээр зөрүүтэй тусгагдсан байна.

*Шийдвэрлэсэн нь:* Аудитын хугацаанд санхүүгийн тайланд залруулав.

5. Үр дүнгийн урамшууллаас 5,873.8 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл тооцоогүй Нийгмийн даатгалын тухай хуулийн 17-ийн "Ажил олгогч, даатгуулагчийн шимтгэл төлөх үүрэг хүлээнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх..." гэсэн заалтыг үндэслэн үр дүнгийн урамшууллаас 5873.8 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг суутган тооцож, төсвийн орлого болгохоор акт тогтоов.

6. Дээврийн засварын 1,200.0 мянган төгрөгийн магадлашгүй ажлын зардлыг гүйцэтгэлийн баримтгүй олгосон нь Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалын 4.12-ийн "төсвийн магадлашгүй ажлын зардлыг зөвхөн захиалагч, гүйцэтгэгч байгууллагын хамтран тогтоосон акт, магадлашгүй ажлын төсөв, гүйцэтгэлийг үндэслэн олгоно." гэсэн заалттай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх..." гэсэн заалтыг үндэслэн 1,200.0 мянган төгрөгийг төлүүлэхээр акт тогтоов.

### 2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Өнөр бүл хүүхдийн төвийн тайлангийн аудитаар анхаарал хандуулвал зохих дараах асуудал байна. Үүнд:

1. 1982 онд ашиглалтад орсон, тус төвийн тайланд бүртгэлтэй ч бодитоор оршин байхгүй дараах хөрөнгүүд байна. Үүнд:
  - 6,756.0 мянган төгрөгийн өртөгтэй, тэг төгрөгийн дансны цэвэр дүнтэй Клуб,
  - 175.0 мянган төгрөгийн өртөгтэй, тэг төгрөгийн дансны цэвэр дүнтэй Худгийн барилга,
  - 19,368.3 мянган төгрөгийн өртөгтэй, тэг төгрөгийн дансны цэвэр дүнтэй Склад,
  - 15,497.6 мянган төгрөгийн өртөгтэй, тэг төгрөгийн дансны цэвэр дүнтэй Талхны байр.
2. Мөн дараах хөрөнгүүдийн өмчлөлийн хувьд маргаантай байна. Үүнд:
  - 1982 онд ашиглалтад орсон, 17,500.0 мянган төгрөгийн өртөгтэй, тэг төгрөгийн дансны цэвэр дүнтэй Ажилчдын байр,
  - 1995 онд ашиглалтад орсон 5,145.0 мянган төгрөгийн өртөгтэй, тэг төгрөгийн дансны цэвэр дүнтэй Ногооны зорь.

Дээрх асуудлуудыг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай.

Өнөр бүл хүүхдийн төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар анхаарал татах бусад чухал асуудал гараагүй болно.

## **2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Өнөр бүл хүүхдийн төвийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 1,766,044.9 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Өнөр бүл хүүхдийн төв нь урсгал үйл ажиллагааны санхүүжилтээр 1,766,044.9 мянган төгрөгийн санхүүжилт авснаас гүйцэтгэлээр 1,747,742.8 мянган төгрөг зарцуулж, 18,322.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж 98.9 хувийн биелэлттэй байна. Төсөвт зардлын хэмнэлт нь байр ашиглалтын зардал төлөвлөсөн хэмжээнээс 15,043.1 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

## **2.11 Шилэн дансны мэдээлэл**

Өнөр бүл хүүхдийн төв Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## **2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100.0 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### **2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Өнөр бүл хүүхдийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Өнөр бүл хүүхдийн төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Өнөр бүл хүүхдийн төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв.

#### **3.1 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

Бараа материал дансанд 20,130.2 мянган төгрөгийн материал, үндсэн хөрөнгө дансанд 15,499.8 мянган төгрөгийн хөрөнгө шууд гэрээ байгуулан худалдан авсан байна.

Энэ нь үнэн зөв, бодитой оршин байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 7.1-ийн “Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна”, Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолд заасан шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг баримтлаагүй байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Хоол хүнс, хувцас зөөлөн эдлэл зэрэг бараа материалуудыг зориулалт бусаар худалдан авсан, зарцуулсан байх.

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах.

##### **3.1.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

## **3.2 Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт**

### 3.2.1 Илрүүлэлт:

2018 онд “Болор хээ” ХХК, “Харшийн гэгээ” ХХК, “Налайх сайн булаг” ХХК-иуд нь 15,190.0 мянган төгрөгийн хоол хүнсний материал илүү, 12,170.0 мянган төгрөгийн материал дутуу нийлүүлсэн нь 2018 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр дээрх компаниудтай байгуулсан худалдах, худалдан авах тухай гэрээний 6-ийн “Нийлүүлэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлбөрийг үндэслэн гэрээний бүх нөхцөл болзолд нийцүүлэн барааг нийлүүлэх үүрэг хариуцлагыг хүлээх” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

### 3.2.2 Эрсдэл:

Худалдан авалтыг хууль журмын дагуу зохион байгуулаагүй байх.

### 3.2.3 Өгсөн зөвлөмж:

Гэрээний үүргийн биелэлтийг тооцож, гэрээний үүргээ биелүүлээгүй аж ахуйн нэгж байгууллагуудыг дараагийн сонгон шалгаруулалтанд оруулахгүй байх, гэрээнд үүргээ биелүүлээгүйн хариуцлага алдангийн хэмжээг тусгаж байх.

### 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

## **3.3 Балансын данстай холбоотой асуудал:**

### 3.3.1 Илрүүлэлт:

Жолоочийн шатахуун зарцуулалтын тооцоонд 2,500.0 мянган төгрөгийн шатахууны тооцоог анхан шатны баримтын бүрдүүлбэр дутуу баримтаар зарцуулсан байна.

Энэ нь үнэн зөв, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 13.7-ийн “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 13.5-ийн “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно”, Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна” гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

### 3.3.2 Эрсдэл:

Шатахуун, тээврийн зардал төсөв, төлөвлөгөөнөөс хэтэрсэн, буруу илэрхийлэгдсэн байх.

### 3.3.3 Өгсөн зөвлөмж:

“Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 13.7-ийн “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”... гэсэн заалтыг мөрдөж ажиллах, шатахуун зарцуулалт болон автомашины гүйлтийн баримтыг тухай бүр хөтөлж тооцоо бодож байх, суудлын автомашинуудын спидометрийн заалтыг засварлан хэвийн ажиллуулах.

### 3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

## **3.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа**

### 3.4.1 Илрүүлэлт:

Мөнгөн хөрөнгийн дансны зарлагын гүйлгээний 20.5 хувьд аудитын түүврийн сорил хэрэгжүүлэхэд 4,043.4 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй зарцуулсан байна.

Энэ нь үнэн зөв, бодитой оршин байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 13.7-ийн "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

#### 3.4.2 Эрсдэл:

Холбогдох заавар, журмыг мөрдөөгүй байх

#### 3.4.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"... гэсэн заалтыг мөрдөж ажиллах, мөнгөн хөрөнгийг анхан шатны баримтгүй зарцуулахгүй байх.

#### 3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

##### 4.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>190,849,082.79</b>	<b>268,483,374.44</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	-
31110	Төгрөг	-	-
<b>32</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	-	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	2,966,315.08
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	135,850.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	-	2,830,465.08
3351	Байгууллагаас авах авлага	-	2,830,465.08
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	190,849,082.79	265,517,059.36
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	23,096,274.73	18,703,630.00
35110	Тусгай зориулалттай материал	17,000,940.00	17,000,940.00
35130	Эм боох материал	6,095,334.73	1,702,690.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	167,752,808.06	246,813,429.36
35410	Бичиг хэргийн материал	1,889,947.50	1,298,240.00
35420	Аж ахуйн материал	5,669,560.00	232,150.00
35430	Сэлбэг хэрэгсэл	215,000.00	857,000.00
35440	Түлш, шатах тослох материал	2,406,000.00	475,000.00
35460	Хүнсний материал	66,786,265.56	159,749,563.56
35470	Бусад хангамжийн материал	90,786,035.00	84,201,475.80
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,529,547,320.84</b>	<b>8,069,620,453.87</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>5,529,547,320.84</b>	<b>8,069,620,453.87</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>5,529,436,209.76</b>	<b>7,590,374,977.38</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	7,110,697,096.00	7,062,610,320.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-2,234,996,783.60	-299,318,116.73
39203	Авто-тээврийн хэрэгсэл	296,689,884.00	296,689,884.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-132,441,550.48	-151,858,050.46
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	659,458,420.30	652,595,672.55
39206	Хуримтлагдсан элэгдэл	-332,333,164.55	-270,645,500.79
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	280,698,017.93	251,651,654.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-147,841,448.08	-98,358,784.15
39214	Бусад үндсэн хөрөнгө	71,394,710.00	152,009,451.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-46,918,499.76	-1,031,080.04
39217	Ном	5,029,528.00	5,029,528.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>111,111.08</b>	<b>479,245,476.49</b>
39301	Програм хангамж	4,447,000.00	4,447,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-4,335,888.92	-4,439,083.51
39303	Бусад биет бус хөрөнгө	-	479,237,560.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>5,720,396,403.63</b>	<b>8,338,103,828.31</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>37,467,920.00</b>	<b>227,470.70</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>37,467,920.00</b>	<b>227,470.70</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>37,467,920.00</b>	<b>227,470.70</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	37,467,920.00	-
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	<b>227,470.70</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	-	227,470.70
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>5,682,928,483.62</b>	<b>8,337,876,357.60</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>5,682,928,483.62</b>	<b>8,337,876,357.60</b>
511	Засгийн газрын оруулсан капитал	1,267,576,482.00	1,746,814,042.00
51101	Өмч: - төрийн	1,267,576,482.00	1,746,814,042.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>3,633,569,018.39</b>	<b>3,692,468,383.05</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	3,633,569,018.39	3,633,569,018.39
51220	Тайлант үеийн үр дүн	-	58,899,364.66
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	781,782,983.23	2,898,593,932.55
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>5,720,396,403.62</b>	<b>8,338,103,828.30</b>

## 4.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,181,323,557.00</b>	<b>1,960,614,496.01</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>92,305,657.00</b>	<b>61,323,346.01</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	600,000.00	61,302,946.01
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	61,190,746.01
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	61,190,746.01
120009	Бусад орлого	600,000.00	112,200.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	91,705,657.00	20,400.00
122001	Хандив тусламж /дотоод/	91,705,657.00	20,400.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,700,000.00</b>	<b>1,899,291,150.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	1,766,044,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,766,044,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,087,317,900.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,700,000.00	133,246,250.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	133,246,250.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,700,000.00	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,254,711,942.03</b>	<b>1,901,715,131.35</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,254,711,942.03</b>	<b>1,901,715,131.35</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,247,210,254.03	1,877,314,147.53
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	635,674,626.00	849,617,110.92
210101	Үндсэн цалин	635,674,626.00	849,617,110.92
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	70,594,697.00	101,275,309.80
210201	Тэтгэврийн даатгал	45,340,252.77	67,604,814.24
210202	Тэтгэмжийн даатгал	6,080,030.41	8,382,044.35
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,496,336.91	6,988,286.74
210204	Ажилгүйдлийн даатгал	1,243,461.81	1,676,609.44
210205	Эрүүл мэндийн даатгал	12,434,615.10	16,623,555.03
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	68,520,102.36	110,078,788.49
210301	Гэрэл, цахилгаан	22,393,786.00	39,629,487.10
210302	Түлш, халаалт	30,365,672.42	53,792,293.20
210303	Цэвэр, бохир ус	15,760,643.94	16,657,008.19
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	39,595,036.92	71,947,651.39
210401	Бичиг хэрэг	5,808,326.00	10,573,637.50
210402	Тээвэр, шатахуун	14,160,000.00	31,931,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,170,054.92	971,163.89
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,085,000.00	3,326,600.00

Өнөр бүл хүүхдийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,371,656.00	25,145,250.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	253,511,524.50	484,772,799.63
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	13,424,300.67	14,768,844.73
210502	Хоол, хүнс	204,350,983.83	310,205,045.70
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	35,736,240.00	159,798,909.20
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,862,030.00	88,800,489.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	834,200.00	1,309,800.00
210604	Урсгал засвар	4,027,830.00	87,490,689.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	2,003,800.00
210702	Дотоод албан томилолт	-	2,003,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,391,010.00	8,729,086.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	4,445,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,627,600.00	1,700,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,547,370.00	1,688,770.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	632,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	176,000.00
210807	Газрын төлбөр	216,040.00	86,416.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	171,061,227.25	160,089,112.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	900,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,598,800.00	23,721,790.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	164,462,427.25	135,467,322.30
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	7,501,688.00	24,400,983.82
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	7,501,688.00	6,078,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,501,688.00	6,078,100.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	18,322,883.82
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	-
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	18,322,883.82
213304	Хөрөнгийн	-	-
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	-
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-73,388,385.03</b>	<b>58,899,364.66</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	-	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-73,388,385.03</b>	<b>58,899,364.66</b>

### 4.3. АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>1,783,989,600.00</u></b>	<b><u>1,899,291,150.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>600,000.00</b>	-
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	600,000.00	-
120009	Бусад орлого	600,000.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,783,389,600.00</b>	<b>1,899,291,150.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	00.00	1,766,044,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	1,766,044,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,781,689,600.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,700,000.00	133,246,250.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	133,246,250.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,700,000.00	-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>1,783,989,600.00</u></b>	<b><u>1,899,291,150.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,783,989,600.00</b>	<b>1,899,291,150.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,733,726,603.82</b>	<b>1,874,890,166.18</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	858,739,300.00	887,209,604.64
210101	Үндсэн цалин	706,838,700.00	643,901,304.64
210102	Нэмэгдэл	73,606,500.00	141,596,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	78,294,100.00	101,712,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	101,849,600.00	100,587,051.16
210201	Тэтгэврийн даатгал	62,122,200.00	66,916,255.60
210202	Тэтгэмжийн даатгал	7,945,300.00	8,382,244.35
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,931,900.00	6,988,386.74
210204	Ажилгүйдлийн даатгал	1,986,400.00	1,676,609.44
210205	Эрүүл мэндийн даатгал	19,863,800.00	16,623,555.03
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	-	-
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	99,107,362.00	110,078,788.49
210301	Гэрэл, цахилгаан	35,354,400.00	40,261,024.10
210302	Түлш, халаалт	39,075,487.77	53,792,293.20
210303	Цэвэр, бохир ус	24,677,474.23	16,025,471.19
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	57,991,217.82	63,409,963.89
210401	Бичиг хэрэг	8,264,050.00	9,644,200.00
210402	Тээвэр, шатахуун	26,148,000.00	30,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,374,697.82	979,163.89

Өнөр бүл хүүхдийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,745,000.00	3,326,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,459,470.00	19,460,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>586,571,037.00</b>	<b>570,176,693.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,260,010.00	10,264,000.00
210502	Хоол, хүнс	413,141,527.00	406,698,343.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	163,169,500.00	153,214,350.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>13,240,170.00</b>	<b>89,203,089.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,413,200.00	1,727,800.00
210604	Урсгал засвар	11,826,970.00	87,475,289.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>896,000.00</b>	<b>2,003,800.00</b>
210701	Гадаад албан томилолт	-	-
210702	Дотоод албан томилолт	896,000.00	2,003,800.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,503,360.00</b>	<b>8,968,986.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,739,950.00	1,700,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,547,370.00	1,688,770.00
210807	Газрын төлбөр	216,040.00	86,416.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>11,828,557.00</b>	<b>43,252,190.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	910,560.00	900,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,917,997.00	42,352,190.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>50,262,996.18</b>	<b>24,400,983.82</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>47,261,048.00</b>	<b>6,078,100.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,461,048.00	6,078,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,800,000.00	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>3,001,948.18</b>	<b>18,322,883.82</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,001,948.18	18,322,883.82
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>

#### 4.4. АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	1,267,576,482.00	781,782,983.23	344,353,655.86	2,393,713,121.09
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,267,576,482.00</b>	<b>781,782,983.23</b>	<b>344,353,655.86</b>	2,393,713,121.09
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	3,503,604,859.93	3,503,604,859.93
C08	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,267,576,482.00</b>	<b>781,782,983.23</b>	<b>3,633,569,018.39</b>	5,682,928,483.62
D01	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,267,576,482.00</b>	<b>781,782,983.23</b>	<b>3,633,569,018.39</b>	5,682,928,483.62
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,267,576,482.00</b>	<b>781,782,983.23</b>	<b>3,633,569,018.39</b>	5,682,928,483.62
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	2,116,810,949.32	-	2,116,810,949.32
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	479,237,560.00	-	58,899,364.66	538,136,924.66
D09	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,746,814,042.00</b>	<b>2,898,593,932.55</b>	<b>3,692,468,383.05</b>	8,337,876,357.60

#### 4.5. АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,766,044,900.00	1,747,742,787.51	-18,302,112.49	98.96
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,766,044,900.00	1,747,742,787.51	-18,302,112.49	98.96
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,759,702,900.00	1,741,664,687.51	-18,302,112.49	98.96
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	865,336,900.00	865,229,034.97	-107,865.03	99.99
210101	Үндсэн цалин	622,028,600.00	621,920,734.97	-107,865.03	99.99
210102	Нэмэгдэл	141,596,300.00	141,596,300.00	-	100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	101,712,000.00	101,712,000.00	-	100.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	101,361,300.00	100,587,051.16	-774,248.84	99.24
210201	Тэтгэврийн даатгал	67,574,200.00	66,916,255.60	-657,944.40	99.03
210202	Тэтгэмжийн даатгал	8,446,800.00	8,382,244.35	-64,555.65	99.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,757,400.00	6,988,386.74	230,986.74	103.42
210204	Ажилгүйдлийн даатгал	1,689,400.00	1,676,609.44	-12,790.56	99.24
210205	Эрүүл мэндийн даатгал	16,893,500.00	16,623,555.03	-269,944.97	98.40
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	125,121,900.00	110,078,788.49	-15,043,111.51	87.98
210301	Гэрэл, цахилгаан	50,159,700.00	40,261,024.10	9,898,675.90	80.27
210302	Түлш, халаалт	52,286,200.00	53,792,293.20	1,506,093.20	102.88
210303	Цэвэр, бохир ус	22,676,000.00	16,025,471.19	-6,650,528.81	70.67
210304	Байрны түрээс	00.00	00.00		
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	63,430,000.00	63,409,963.89	-20,036.11	99.97
210401	Бичиг хэрэг	9,644,500.00	9,644,200.00	-300.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	30,000,000.00	30,000,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,100,500.00	979,163.89	-121,336.11	88.97
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,225,000.00	3,326,600.00	101,600.00	103.15
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,460,000.00	19,460,000.00	-	100.00
2105	<b>Нормативт зардал</b>	570,109,000.00	568,656,943.00	-1,452,057.00	99.75
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,264,000.00	10,264,000.00	-	-
210502	Хоол, хүнс	405,177,900.00	405,178,593.00	693.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	154,667,100.00	153,214,350.00	-1,452,750.00	99.06
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	11,108,800.00	11,184,430.00	75,360	100.68
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,669,000.00	1,727,800.00	58,800.00	103.52
210604	Урсгал засвар	9,439,800.00	9,456,630.00	16,830.00	100.18
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	2,016,000.00	2,003,800.00	-12,200.00	99.39
210702	Дотоод албан томилолт	2,016,000.00	2,003,800.00	-12,200.00	99.39
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	9,650,700.00	8,968,986.00	-681,986.00	92.94

Өнөр бүл хүүхдийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,685,000.00	4,685,000.00	-	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,006,900.00	1,700,000.00	306,900.00	84.71
210803	Даатгалын үйлчилгээ	1,800,000.00	1,688,770.00	-111,200.00	93.82
210804	Тээврийн хэрэгслийн татвар	632,800.00	632,800.00	-	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	176,000.00	176,000.00	-	100.00
210807	Газрын төлбөр	350,000.00	86,416.00	86,416.00	24.69
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	11,568,300.00	11,545,690.00	-22,610.00	99.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	912,300.00	900,000.00	-12,300.00	98.65
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,656,000.00	10,645,690.00	-10,310.00	99.90
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	6,342,000.00	6,078,100.00	-263,900.00	95.84
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	6,342,000.00	6,078,100.00	-263,900.00	95.84
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,342,000.00	6,078,100.00	-263,900.00	95.84
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,766,044,900.00	1,747,742,787.51	-18,302,112.49	98.96
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,766,044,900.00	1,747,742,787.51	-18,302,112.49	98.96
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,766,044,900.00	1,747,742,787.51	-18,302,112.49	98.96

**5. АУДИТЫН ЯВЦАД ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ**

Огноо:	Аудитын нэр:	<b>Өнөр бүл хүүхдийн төвийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит</b>	Аудитын код:
<b>2018.12.31</b>			<b>САГ-2019/136/СТА-ТШЗ</b>
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Өнөр бүл хүүхдийн төв</b>		/мянган төгрөгөөр/

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
<b>A</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>
1	Дээврийн засварын магадлашгүй ажлын зардлыг гүйцэтгэл 1,200.0 мянган төгрөгийг баримтгүй олгосон байна.	1,200.0	Төлбөрийн акт тогтоох	Захирал Нягтлан бодогч	М.Өлзийчимэг Н.Ууганбаяр
2	Үр дүнгийн урамшууллаас 5,873.8 мянган төгрөгийн Нийгмийн даатгалын шимтгэл тооцоогүй байна.	5,873.8	Төлбөрийн акт тогтоох	Захирал Нягтлан бодогч	М.Өлзийчимэг Н.Ууганбаяр
3	Босго үнээс давсан хөрөнгөөр бараа материал, үндсэн хөрөнгийг шууд гэрээ байгуулан худалдан авсан байна.	20,130.2	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	М.Өлзийчимэг Н.Ууганбаяр
4	Бэлтгэн нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй байна.	2,500.0	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	М.Өлзийчимэг Н.Ууганбаяр
5	Анхан шатны баримтын бүрдүүлбэр дутуу баримтаар шатахуун зарцуулсан байна.	3,020.0	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	М.Өлзийчимэг Н.Ууганбаяр
6	Анхан шатны баримтгүйгээр мөнгөн хөрөнгө зарцуулсан байна.	4,043.4	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	М.Өлзийчимэг Н.Ууганбаяр
<b>Дүн</b>		<b>36,767.4</b>			

